БАТЛАВ

ЗАСАГ ДАРГА О.ӨЛЗИЙБАДРАХ

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Өвөрхангай аймгийн Богд сумын арц 1, 2 хороололд хийх нийтийн эзэмшлийн талбайн тохижилтын ажил нь дараах шаардлагуудыг бүрэн хангасан байна.

1.Ерөнхий шаардлага

1.1 Ажлын талбайн зохион байгуулалт болон иргэдийн аюулгүй байдлыг бүрэн хангасан байх, ажилтнууд хамгаалах хэрэгслэлээр бүрэн хангагдсан байна.

1.2 Барилгын үйлдвэрлэлд дагаж мөрдөх хөдөлмөр, хамгаалал, аюулгүй ажиллагааны норм дүрэм, стандартыг мөрдөж, гарах эрсдлийг гүйцэтгэгч компани бүрэн хариуцна.

1.3 Нийтийн эзэмшлийн талбайг тохижуулах ажлын явцад гарсан хог хаягдлыг төвлөрсөн хогийн цэгт хаях ба ажил дууссаны дараа талбайг цэвэрлэж хүлээлгэн өгнө.

1.4 Гүйцэтгэгч нь ашиглагч, хангагч байгууллагууд болон захиалагчтай уяалдаа холбоотой ажилана.

2. Нийтийн эзэмшлийн талбайг тохижуулах

ажилд тавигдах шаардлага

2.1 Явган зам нь өнгөт хавтан хашлагтай байна. Нийт 900м^2 талбайн өргөн 1,2м, урт 375м байна.

2.2 Хүүхдийн гулсуур тай тоглоом олон үйлдэлтэй, хүүхдийн эрүүл мэнд, хүрээлэн буй орчиндоо хор нөлөөгүй бат бөх чанартай байх

2.3 Гэрэлтүүлэг нь нараар цэнэглэгддэг тухайн орчныг бүрэн гэрэлтүүлэх хүчин чадалтай байх

2.4 Камер нь өнгө дүрсний нягтрал сайн байх

2.5 17,60:8,90 харьцаатай сагсны талбай цутгах, шийд, самбар , тор солих

2.6 Сумын танилцуулах самбар хийж байршуулах, орох, гарах самбарыг будаж өнгийг сэргээх

2.7 Бялдаржуулах тоглоомын эвдэрсэнийг засах, өнгийг сэргээж будах

3. Ажилд хэрэглэгдэх барилгын материалд тавигдах шаардлага

Тухайлсан барилгын ажилд хэрэглэгдэх бүх төрлийн барилгын материал, бүтээгдэхүүн, хавтан, хашлага, хүүхдийн тоглоом түүний тоног төхөөрөмжүүд, холбоо, цахилгааны утас гэх мэт нь Монгол Улсын болон олон улсын стандартын шаардлагад нийцсэн, барилга байгууламжийн норм, нормативийн баримт бичиг, зураг төслийн шаардлагыг бүрэн хангасан байх бөгөөд шинэ, ашиглагдаагүй, орчин үеийн дэвшилтэт тоног төхөөрөмж байна.

Монгол Улсын үндэсний стандарт, эсхүл тухайлсан өөр стандартыг хэрэглэхээр заасан тохиолдолд бараа, материал, шинж чанар нь энэ стандартыг хангах буюу түүнээс илүү бол хүлээн зөвшөөрнө.

Гэрээнд өөрөөр заагаагүй бол техникийн тодорхойлолтод дурдсан нийлүүлэгдэх бараа, материал болон хийгдэх, эсхүл турших ажлын стандарт, кодыг уг стандарт буюу кодын тухайн үед мөрдөгдөж буй хувилбарт тодорхойлсоноор хэрэглэнэ. Үндэсний стандарт, кодыг заасан тохиолдолд түүнтэй жишихүйц, эсхүл түүнээс илүү чанартай бусад стандарт, кодыг төслийн захиалагч байгуулагат бичгээр зөвшөөрөл олгосон бол хүлээн зөвшөөрнө. Заасан стандарт болон санал болгосон хувилбарт стандартын хоорондын ялгааг нийлүүлэгч бичгээр тодорхойлон гаргах бөгөөд зөвшөөрлийг авахыг хүсч байгаа өдрөөс ажлын 3-аас доошгүй хоногийн өмнө төслийн захиалагч байгууллагад хүргүүлнэ. Төслийн захиалагч байгууллага эдгээр зөрүүг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд нийлүүлэгч бичиг баримтад заасан стандартыг хангах үүрэгтэй.

Ажлын тоо хэмжээ жагсаалт

д/д	Ажлын нэр	нэгж	Тоо хэмжээ
1	375м урт, 1,2м өргөнтэй явган зам хашлагтай хийж гүйцэтгэх	$м^2$	900
2	Гулсууртай хүүхдийн тоглоом 990:335:380 хэмжээтэй төмөр шонтой байх	ш	1
3	Гэрэлтүүлэг нараар асдаг өдөр шөнийн тохируулагтай 4м өндөр төмөр шонтой, 800w доошгүй чадалтай 300-350$м^2$ талбайг гэрэлтүүлэх	ш	4
4	Гадна ір камер өдөр шөнийн тусгалтай, харах өнцөг нь 90 градус шөнийн тусгал 40м багагүй байх	ш	2
5	17,60:8,90 харьцаатай 10 см зузаантай сагсны талбай цутгах,	$м^2$	156,64
6	Сагсны самбар	ш	1
7	Сагсны Шийд	ш	1
8	Сагсны тор-2 Гар бөмөгийн тор-2	ш	4
9	Бялдаржуулах тоглоомын эвдэрсэнийг засах, өнгийг сэргээж будах	ш	8
10	Сумын танилцуулах самбар 1.5:1.0	ш	2
11	Орох, гарах самбарыг будаж өнгийг сэргээх	ш	4
12	Явган хүн орох гарах хаалт засах, салсан хашааг гагнах		
13	“Ногоон бүс төслийн хүрээнд“ теле камерын хяналтын дэд төвд ухаалаг төхөөрөмж, видео удирдлагын системийг суурьлуулах лиценз	ш	2
14	Саадны гадна дотор элс зөөх	$М^2$	3